МАРГААНТАЙ
ГҮЙЛГЭЭ

МАРГААНТАЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТУХАЙ

Харилцагч карт болон цахим банк үйлчилгээгээр хийсэн үл хүлээн зөвшөөрсөн, эргэлзээтэй, маргаан үүсгэсэн гүйлгээг **МАРГААНТАЙ ГҮЙЛГЭЭ** гэнэ.

МАРГААНТАЙ ГҮЙЛГЭЭ ГАРСАН ТОХИОЛДОЛД

МАРГААН ХҮЛЭЭН АВАХ БОЛОН ШИЙДВЭРЛЭХ ХУГАЦАА

№	Сүлжээ суваг	ATM	Мерчант	Цахим банк
1	ХХБ-ны сүлжээ	30 хоног	30 хоног	30 хоног
2	Цахим банкны сүлжээ	30 хоног	30 хоног	30 хоног
3	ҮЦГТ-ийн сүлжээ	30 хоног	30 хоног	
4	Олон улсын сүлжээ	120 хоног	75-120 хоног	

МАРГААНТАЙ ГҮЙЛГЭЭ ХҮЛЭЭН АВАХ СУВАГ

Карт эзэмшигч

- 1900 1977, 1800 1977 дугаарт холбогдон хүсэлт гаргах;
- info@tdbm.mn хаягт хүсэлт гаргах;
- Өөрт ойрхон салбарт хандан хүсэлт гаргах;
- Бусад банкны харилцагч бол карт гаргагч банкандаа хандах;
- TDB Online банкандаа нэвтрэн хүсэлт гаргах боломжтой.

Картаар үйлчлэгч байгууллага

- 1900 1977, 1800 1977 дугаарт холбогдон бүртгүүлэх;
- Албан бичиг, гүйлгээний баримт болон холбогдох баримтыг эх хувиар нь салбарт өгөх эсвэл info@tdbm.mn хаягт и-мэйлээр илгээх.

МАРГААНТАЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТӨРӨЛ

- Алдаатай гүйлгээнд үйлчилгээ үзүүлэх;
- Үйлчилгээний байгууллагаас бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргээгүй;
- Хуурамч картаар хийгдсэн гүйлгээ;
- Луйврын болон зөвшөөрөлгүй гүйлгээ;
- Хожуу нэхэмжлэл ирсэн гүйлгээ;
- Давхар болон илүү дутуу дүнгээр уншигдсан гүйлгээ;
- Амжилтгүй болсон гүйлгээ;
- Карт уншуулах үед баримт гараагүй тохиолдолд бэлнээр эсвэл төлбөрийн бусад хэрэгсэлээр төлөх;
- Онлайн банкаар болон QPay-ээр хийгдсэн өөрийн үл хүлээн зөвшөөрсөн гүйлгээ багтана.

АНХААРАХ ЗҮЙЛС

МЕРЧАНТЫН ХУВЬД:

- Байгууллага хүсэлт гаргаж байгаа бол картын дугаар бүтнээр бичихийг хориглоно. Гүйлгээний дүн, картын эхний болон сүүлийн 4 орон, гүйлгээний огноо, терминал дугаарыг тодорхой бичсэн байх, албан бичгийн агуулга тодорхой зөв байх, мөн эргэж холбоо барих мэдээллээ үлдээх;
- Картаар гүйлгээ хийсэн тохиолдолд гүйлгээ амжилттай хийгдсэн эсэхийг сайтар шалгасны дараа үйлчилгээ үзүүлж байх, алдаа гарсан даруйд 1900 1977, 1800 1977 дугаарт холбогдон гүйлгээг шалгуулах;
- ПОС терминал дээр гүйлгээ амжилттай болж баримт хэвлэгдсэн, баримт дээр PURCHASE болон ХУДАЛДАН АВАЛТ гэсэн бичиг гарсан байх.

КАРТ ЭЗЭМШИГЧИЙН ХУВЬД:

- Картын мэдээллээ бусдад өгөхгүй байх, луйвар гарах эрсдэлээс өөрсдийгөө сэргийлэх;
- Картаар хийгдсэн гүйлгээ амжилтгүй болсон тохиолдол бүрт дансны хуулгаа шалгасны дараа дахин картаа уншуулж байх;
- Гүйлгээ хийж байгаа үед картын ПИН кодыг 1 удаа л хийж байх, дахин хийх шаардлага гарвал дансны хуулгаа шалгах;
- Картаа хаясан, гээсэн тохиолдолд 1900 1977, 1800 1977 дугаарт холбогдож картаа хаалгах, эсвэл TDB Online банкандаа нэвтрэн орж картаа хаах шаардлагатай.

TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:

Нэмэлт үйлчилгээ: +976 1900-1977
Ерөнхий зөвлөгөө мэдээлэл: +976 1800-1977
И-мэйл: info@tdbm.mn
Вэб хаяг: www.tdbm.mn